

Гарчиг

1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	2
2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга.....	7
3. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөөлөл.....	8
4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	11
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
5.1 Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
5.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	17
5.3 Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө	17
5.4 Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	19
5.5 Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	20
5.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
5.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	21
5.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	23
5.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	25
6. БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө.....	30

Хавсаргах материал

1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээ
2. Тусгай зөвшөөрлийн хуулбар /Хуулиар тусгай зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны хувьд/
3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас /аж ахуйн нэгж бөглөх/
4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөний баталгаажсан нүүр, байгаль орчинтой холбоотой маягтууд /маягт 1.1, 2.1, 6.2, 7.1, 10 .../
5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэвлэмэл хэлбэрээр 3 хувь, мөн цахим хэлбэрээр

1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 төслийн талбайн байршил

Төсөл хэрэгжүүлэгч: “Баянгол эко Заамар” ХХК

УБД: 9011408108, РД: 5906865

Төслийн нэр: “Баянголын голдирол алтны үүсмэл болон шороон ордыг драгаар ашиглах” төсөл


Төслийн зорилго: Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлж алт олборлох

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-000290


Төслийн талбайн байршил: Төслийн талбайн MV-000290 ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбай нь, засаг захиргааны хувьд Төв аймгийн Заамар сумын Баянголын гольдрол нэртэй газарт байрлана. Улаанбаатар хотоос баруун хойшоо 220 км, Төв аймгийн Заамар сумаас баруун хойш 40 км тус тус зайтай оршино. Мөн орд нь Монгол улсын хэвтээ тэнхлэгийн авто зам болох Улаанбаатар-Архангай чиглэлийн хатуу хучилттай авто замаас 70 км зайд оршдог. Заамарын Баянголын гольдролын үүсмэл шороон орд нь Туул голын хөндийн татамд болон хөндийн дэвсэг дээр, хажуугийн салаа болох Баянгол, Хайлааст горхийн цутгалаас доош байрласан. Заамарын алтны зангилааны алтны шороон ордуудыг ашиглахтай холбогдуулж Заамар сум нь сүүлийн жилүүдэд дэд бүтэц эрчимтэй хөгжсөн. Ордын талбай руу жилийн аль ч улиралд орон нутгийн замаар саадгүй явах боломжтой байдаг.

Хүснэгт 0-1. Талбайн солбицол

№	Уртлаг			Өргөрөг		
1	104°	30'	32.6"	48°	22'	42.63"
2	104°	30'	32.65"	48°	22'	37.13"
3	104°	30'	34.89"	48°	22'	37.13"
4	104°	30'	34.9"	48°	22'	35.84"
5	104°	30'	34.92"	48°	22'	35.2"
6	104°	30'	36.07"	48°	22'	35.2"
7	104°	30'	36.1"	48°	22'	32.95"
8	104°	30'	36.15"	48°	22'	26.79"
9	104°	30'	34.7"	48°	22'	26.78"
10	104°	30'	34.75"	48°	22'	20.94"
11	104°	30'	30.86"	48°	22'	20.94"
12	104°	30'	30.93"	48°	22"	13.82"
13	104°	30'	28.02"	48°	22'	13.8"
14	104°	30'	28.06"	48°	22'	8.94"
15	104°	30"	27.09"	48°	22'	8.94"
16	104°	30'	27.14"	48°	22'	4.08"
17	104°	30'	26.17"	48°	22'	4.08"
18	104°	30'	26.21"	48°	21'	59.55"
19	104°	30'	24.75"	48°	21'	59.53"
20	104°	30'	24.78"	48°	21'	57.28"



Зураг 0-1. Талбайн байршил



1.2 Ордын ашиглалтын системийн сонголт

Ордын алт агуулсан элсний давхарга нь дунджаар 4.8 м, 2.5-3.2 градусын налуутай, хэвтэш маягийн, зүүн хойноос баруун урагш сунаж тогтсон жалгын шороон орд юм. Ордод өмнө нь драгаар олборлолт явуулж байсан.

Хүснэгт 0-2 Ашиглалтын технологийн схем

Ашиглалтын систем	Үндсэн ажил	Технологийн процесс
Драглайны шидэлттэй систем	Хөрс хуулалт	· Ухах
		· Шидэх (Гадаад ба Дотоод овоолго)
	Элс олборлолт	· Ухах
		· Угаах үйлдвэр

1.2.1 Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн хэмжээс

Ил уурхайн үндсэн хэмжээсүүдийг хуучин ажиллаж байсан Драгийн олборлолтын үзүүлэлтүүдтэй жишиг болгон авсан.

Доголын өндөр: Элсний бохирдлыг бага байлгах, ухаж ачих тоног төхөөрөмжийн ажиллах нөхцөл зэргийг үндэслэн ил уурхайн ажлын доголын өндрийг $H_d=4-7$ м байхаар сонгосон.

Ажлын доголын хажуугийн өнцөг: Ажлын доголын хажуугийн өнцгийг чулуулгийн шинж чанар, аюулгүй ажиллагаа зэргийг тооцож $\alpha_d=45-50$ градус байхаар сонгосон.

Ил уурхайн ерөнхий хажуугийн өнцөг: Уурхайн ашиглалтын технологийн элементүүд болох ажлын болон ажлын бус доголын өндөр ба доголын өнцөг, тээврийн ба аюулгүйн тавцангийн өргөн зэргийг тооцон уурхайн хажуугийн өнцгийг 45-50 градус байхаар сонголоо.

Хүснэгт -3 Ил уурхайн үндсэн хэмжээс

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Ажлын доголын өндөр	м	4-7
2	Ажлын бус доголын өндөр	м	4-7
3	Ажлын доголын хажуугийн өнцөг	Градус	45-50

1.2.2 Уурхайн хүчин чадал, ажиллах горим:

Баянголын гольдрол үүсмэл шороон орд 2024 оны 6-р сараас эхлэн ажиллана. Уулын ажил хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Монгол улсын хөдөлмөрийн хуулинд заасны дагуу жилд амрах баяр ёслолын хоног цаг тооцон хоног ажиллахаар тооцлоо.

Хүснэгт -4 Уурхайн ажиллах горим

жил	сар	Сарын хоног	Баяр ёслол	Техникийн саатал	Сард ажиллах хоног
2026	5	20		10	20
	6	31	-	7	24
	7	31	5	3	23
	8	30	-	7	23
	9	31	-	7	23
	10	30	-	10	20
Нийт		148	5	23	133

1.2.3 Уулын ажлын төлөвлөлт:

- 2 2026 оны ашиглалтын хугацаанд 453260 м³ хөрс хуулж, **507430** м³ элс олборлох ба хөрс хуулалтын итгэлцүүр 0.8 м³/м³ байна. 2026 оны 05 дугаар сараас улын ажил эхлэх ба C15, C16 блокийн хүрээнд ажиллана.

Хүснэгт 0-5 Олборлолтын төлөвлөгөө

№	Хөрс хуулалт, м ³	Элс олборлолт, м ³	Элс олборлолт, м ³ сийрэгжисэн	Кхх, м ³ /м ³
2026	453260	507430	548058.5	0.8
Нийт	453260	507430	548058.5	0.8

1.3 Хог хаягдал

Хатуу хог хаягдал:

Уурхайн ажилчдын хотхонд тогтмол 68 хүн ажиллана гэж үзвэл:

Нийт 68 хүн * 0,3 кг/хоногт = 20.4 кг/хоногт, жилд ойролцоогоор 3.2 тн ахуйн хатуу хог хаягдал гаргахаар байна.

Ажилчидын түр амьдрах байрны орчинд доорх нэр төрлийн хатуу хог хаягдал гаргахаар байна. Үүнд:

- Хүнсний зүйлийн сав,баглаа,боодол
- Бие засах газрын хаягдал
- Полиэтилен уут,баглаа,боодол
- Хоолны үлдэгдэл
- Үйлдвэрийн болон засварын хэсгээс гарах хаягдал
- Бусад

Тус компани нь төслийг хэрэгжүүлэх явцдаа хатуу хог хаягдлыг зайлуулах асуудлыг “Хог хаягдлын тухай” улсын хуульд заасны дагуу холбогдох байгууллагатай “Хог хаягдал тээвэрлэн зайлуулах” гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь хатуу хог хаягдлын түр хадгалах цэгийг зонхилох салхиний доод талд битүү тагтай зориулалтын саванд хадгалах ба байгууламжаас 60 м-с багагүй зайтай байрлуулах ёстой.

Үйлдвэрийн хатуу хог хаягдал:

Овоолго болон шлам нь уурхайн хатуу хог хаягдлыг голлон бүрдүүлдэг. Уурхайн ажиллагаанд химийн элдэв бодис хэрэглэгүй тул үйлдвэрлэлийн хатуу хог хаягдал нь бохирдолгүй, найрлагын хувьд байгалийн анхны байдлаасаа бараг ялгагдахгүй. Байгаль орчныг бохирдуулах хог хаягдлыг голлон хаягдал төмөрлөг, багаж, машин механизм, барилгын хаягдал гэх мэт томоохон зүйлс эзэлдэг. Байгаль орчныг бохирдуулах аюул бүхий хог хаягдалд машин механизмын тосолгооны бодисууд, аккумулятор, төрөл бүрийн зай хураагуурууд, будаг, уусгагч, хүчил, шүлт, цэвэрлэгээний бодисууд, хэрэглэгдсэн шүүлтүүрүүд, гидравликийн шингэн, хөргөгч, хортон ургамал шавьж устгагч зэрэг бусад химийн бодис бүхий шингэн болон хатуу хаягдлууд орно. Эдгээр бодисуудыг хүний амьдрах орчин, газрын гадаргуу, хөрсний усанд нөлөөлөхөөргүй зайтай газар тусгай бэлтгэсэн нөхцөлд хадгалж, дахин боловсруулах буюу 2 догч түүхий эд авах байгууллагад нийлүүлнэ.

Шингэн хог хаягдал:

Төсөл хэрэгжих үеийн шингэн хаягдлын эх үүсвэр нь:

- Элс баяжуулах явцад ус бохирдох

- Хоол бэлтгэлийн явцад гарсан бохир ус
- Цэвэрлэгээнд хэрэглэсэн бохир ус
- Ариун цэврийн өрөөнүүдээс гарах бохир ус зэрэг болно.

$(68 \text{ хүн} * 180 \text{ л/хоног} * 153 \text{ өдөр}) / 1000 = 1264.08 \text{ м}^3 / \text{жилд}$ шаардлагатай ахуйн хэрэглээний усны хэмжээ/

Нийт хэрэглэх усны хэмжээ 1 жилд 1264.08 м³ цэвэр ус ашиглахаар байна. Үүний 70% буюу 884.8 м³ /жилд шингэн хаягдал гарах тооцоотой байна./

Ахуйн бохир усны асуудал дараахи шат дараалсан үйл ажиллагааны дагуу шийдвэрлэгдэж байх ёстой:

- Байгууламж бүр дээр бохир усны нөхцөл байдлын хяналтыг хөтлөх,
- Асуудлыг шийдэх өөр боломжит нөхцөлүүдийг боловсруулах,
- Бохир ус цэвэрлэгээний байгууламжуудыг байнгын хэвийн ажиллагаанд байлгах,
- Бохир усыг ашигтайгаар ашиглах боломжыг судлан тогтоох,
- Бохир усыг хөрсөнд шингэхээс сэргийлж бүрэн тусгаарлах

Үйлдвэрлэлийн шингэн хаягдал:

Туул голоос эсвэл гүн шүүрлийн усаар драгийг хөвүүлэхэд болон илүүдэл шороо, шламыг эцсийн байрлалд асгах зэрэг үйлдвэрлэлд хэрэглэх ус технологт чухал ач холбогдолтой. Ердийн ажиллагааны үед бүх ус эргэлтэнд орж дахин ашиглагдаж байх бөгөөд хаягдал ус гарахгүй байхаар тооцоологдсон. Төлөвлөлтөөс гадуур хаягдал ус гаргахгүйн тул тунгаах цөөрөм, драг хөвөх цөөрмүүдийг тооцооны дагуу байгуулах бөгөөд энэ нь үер ус, шуурганы үед ч хэрэглээний усыг хянаж байх болно. Усны булигарталт рН-ын хэмжээг тогтмол хэмжиж, бусад давс метал зэрэг үзүүлэлтүүдийг байнга шалгаж байх шаардлагатай. Ашиглалтын усанд ямар нэг химийн бодис хийгдэхгүй учир булингарталтаас өөр чанарын мэдэгдэхүйц өөрчлөлт гарахгүй гэж үзэж байна. Ашиглалт дууссан тунгаах болон драг хөвөх цөөрмийн ус уурших ба буцаж шүүгдэн шингэх юм. Хэрэв хаягдал усыг зайлуулах шаардлага гарвал усны чанарын шинжилгээ хийж байгалийн усанд сөрөг нөлөөлөл учруулахгүй байх бүх арга хэмжээг авна.

Дуу чимээний түвшин: Уурхайн үйл ажиллагаа нь Туулын хөндий дэх бусад 13 уурхай болон бусад дэд бүтэц, үйлчилгээний байгууламжуудтай ойролцоо явагдах юм. Эдгээр уурхайнууд, машин техникүүдийн дуу чимээ бүгд нийлж орчны дуу чимээний фоныг бүрдүүлж байгаа бөгөөд үүнийг тус уурхайн орчноос гарч байгаа дуу чимээний эх үүсвэр тодорхой хэмжээгээр нэмэх болно. Үүнд мөн тус бүс нутгийн газрын гадаргын тогтоц, голын дагуух ургамалжилтын байдал зэрэг нөлөөлнө. Энэ бүхнийг харгалзан уурхайн орчны ердийн нөхцөл дэх дуу чимээний түвшин 30-40 децибалл (Дц) байх болно гэж үзэж байна. Дуу чимээний хэмжилтийн үр дүнгээс үзэхэд хамгийн их түвшин суурингийн орчинд 88 Дц хэмжигдсэн ба ерөнхий фон нь 40-55 Дц байлаа. Энэ түвшин нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын болон Монгол улсын Агаарын чанарын стандарт MNS 4585-2007-д хот суурины дотно гадна орчны агаарт өглөөний 07 цагаас 23 цаг хүртэл 60 Дц-ээс, шөнийн 23 цагаас өглөөний 07 цаг хүртэл 45 Дц –ээс тус тус бага байх заалтын хүрээнд байх ба аюулгүйн бүсийн гадна эрс буурсан байх учир хүрээлэн буй орчинд дуу чимээний сөрөг нөлөө үзүүлэхгүй.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нийгэм-эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ /НЭЗНҮ/ нь шинэ тутам хөгжиж байгаа судалгааны чиглэл бөгөөд төсөл, хөтөлбөрийн нийгмийн үр дагаврыг хэрэгжилтийн үе шаттай нь уялдуулан аль болох урт хугацааны баримжаатайгаар тодорхойлох оролдлого юм. НЭЗНҮ нь төлөвлөн хэрэгжүүлж буй ажиллагаа (бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл гэх мэт)-ны нийгмийн зайлшгүй болон урьдчилан төсөөлөөгүй эерэг ба сөрөг үр дагавар, тэдгээрээс үүдэн бий болох нийгмийн өөрчлөлтийг задлан шинжлэх, үнэлэх, менежментийн процессыг өөртөө агуулж байдаг. Аливаа ажиллагаа, арга хэмжээний хүрээнд хүмүүний амьдрахуй ба байгаль орчныг илүү тогтвортой, тэнцвэртэй болгоход НЭЗНҮ-ний үндсэн зорилго чиглэдэг. Энэ бүлэгт нүүрс угаах үйлдвэр төслөөс орон нутгийн нийгэм, эдийн засагт гарах шууд болон шууд бус нөлөөллийн талаар тусгалаа. Улс, орон нутгийн хөгжилд төслийн үзүүлэх нөлөөлөл нь ихэнхдээ эерэг байх төлөв харагдаж байна. Эдийн засаг, бизнес, үйлчилгээ, ажил эрхлэлт зэрэг олон салбарт эерэг нөлөөллүүд гарах магадлалтай. Гэхдээ орон нутгийн захиргаа ил тод, иргэдтэйгээ хамтран зөвлөлдөж ажиллах, төслийн өгөөжийг аль болох өргөжүүлэх талаар санаачилга гаргах шаардлагатай болж байна.

2.1 Төслөөс орон нутгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

Заамар сумын нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт -6. Төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Нийгэм эдийн засгийн бүрэлдэхүүн	Төслөөс учирч болзошгүй нөлөөлөл	
	Эерэг нөлөөлөл	Сөрөг нөлөөлөл
Нутгийн иргэдэд үзүүлж болзошгүй нөлөөлөл		
Ажил эрхлэлт, амьжиргаа	•	
Шилжилт хөдөлгөөн	•	•
Нүүлгэн шилжүүлэлт		
Эдийн засгийн хөгжилд гарч болох нөлөөлөл		
ТӨВ АЙМАГ	•	
ЗААМАР СУМ	•	
Дэд бүтэц		
Төв аймаг	•	
Заамар сум	•	
Соёлын өвд учирч болзошгүй нөлөөлөл		
Археологийн дурсгал		
Түүх соёлын дурсгалт газар, ТХГН		

Төслийг хэрэгжүүлснээр тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй зарим уурхайнуудын үйл ажиллагаанд эергээр нөлөөлөх бөгөөд шинээр ажлын байр бий болгох, улс болон орон нутгийн төсөвт татвар болон бусад хураамжийн орлого төвлөрүүлж, орон нутгийн хөгжилд нийгмийн хариуцлагын хүрээнд хувь нэмэр оруулах ихээхэн ач холбогдолтой.

2.2 Төслөөс орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөлөл

Төслөөс орон нутгийн хүн амд үзүүлэх нөлөөллийг ажил эрхлэлт, амьжиргаа, шилжилт хөдөлгөөн, нүүлгэн шилжүүлэлтийн хувьд авч үзлээ.

Төсөл хэрэгжсэнээр сумын түвшинд ажил эрхлэлт, үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэх үүнийг дагаад иргэдийн амьжиргаанд эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтой. Гэхдээ тус төсөл нь 7 жилийн хугацаанд хэрэгжих тооцоолол гарсан бөгөөд орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөлөл нь богино хугацааны шинж чанартай байхаар байна. Эдгээрт:

- ✓ Ажил эрхлэлт нэмэгдэх
- ✓ Бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлснээр орлого нэмэгдэх, иргэдийн амьжиргаа сайжрах
- ✓ Сумын орлогын эх үүсвэр бэхжих
- ✓ Бизнес хөгжихөд таатай орчин бүрдэх

Харин төсөл хэрэгжих үед тухайн орон нутагт эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөтэй хэдий ч төсөл хаагдсаны дараа тухайн орон нутгийн хэмжээнд /аймаг, сум, баг/ эдийн засгийн тогтворгүй байдал үүсч болзошгүй.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Баянгол эко Заамар” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Баянголын голдирол алтны үүсмэл болон шороон ордыг драгаар ашиглах” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй хоёр эх үүсвэрийг авч үзэж байна. Үүнд:

- ✓ Элс олборлох процесс

ШИМТ ХӨРС ХУУЛАЛТ ► ХӨРС ХУУЛАЛТ ► АЛТ АГУУЛСАН ЭЛСНИЙ ДАВХАРГА ОЛБОРЛОЛТ

- ✓ Элс баяжуулах процесс

АНХДАГЧ ЭЛС ► ХҮРДЭН ШИГШҮҮРЭЭР УГААН АНГИЛАЛТ ► ГҮН ДҮҮРГЭЛТИЙН ШЛЮЗ ► НАМ ДҮҮРГЭЛТИЙН ШЛЮЗ ► СЭГСРЭХ ШИРЭЭ ► ГАР ТЭВШ ► АЛТНЫ БАЯЖМАЛ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны төлөв байдал, дүгнэлт, өмнө хийгдсэн байгаль, нийгэм эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, газар дээр нь ажилласан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн “Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга” (checklist)-аар тодорхойлсон болно. Үнэлгээг дараах алхмуудаар гүйцэтгэв. Үүнд:

- ✓ Байгаль орчны үнэлгээний өмнөх үе шатуудад тодорхойлсон төслийн байгаль орчин, нийгмийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийн цар хүрээ, эрчим, хугацаа, шинж чанарыг нарийвчлан тодорхойлж, тоон ба чанарын шинжилгээ хийх.
- ✓ Болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний мэдээлэлд буулган судалж, сөрөг нөлөөллийн тархалт, үр дагаврыг үнэлэх.
- ✓ Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд төсөл хэрэгжих болон төслийн нөлөөлөлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн

төлөв байдал, бохирдол, доройтлын түвшин тогтоох нэмэлт судалгаа, ажиглалт, хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх зэрэг орно.

Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм.

Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны өөрчлөлт, нийгэм- эдийн засаг, бусад гэсэн 5 үндсэн бүлэгт багцлан хувааж, магадлан жагсаах аргаар судлав. Нөлөөллийг сөрөг (-), эерэг (+), нөлөөлөлгүй (0) гэсэн 3 бүлэглэлээр үнэлж, эрчимжилтийг: “бага”, “дунд”, “хүчтэй” гэсэн 3 зэргээр тогтоож, хэлбэр, хугацаа, чиглэлээр нь үнэлсэн болно.

Хүснэгт 1. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа			Нөлөө		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө	Богино	Дунд	Урт	Буцах	Буцалтгүй	Бага	Дунд	Хүчтэй
Байгалийн экосистемийн өөрчлөлт											
Газрын доорх усны урсац, горим, чанар өөрчлөгдөх	-					-		-			-
Уурхайн ухаш, хөрсний овоолго, зам болон барилга байгууламжаас ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах	-					-		-			-
Уурхайн үйл ажиллагааны улмаас хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах, шимт байдал алдагдах	-					-		-			-
Уурхайн олборлолтын улмаас геологийн тогтоц өөрчлөгдөх	-					-		-			-
Хүнд машин механизм, техник, тоног төхөөрөмж, хүний үйл ажиллагаатай холбоотойгоор ойр орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай өөрчлөгдөх, хумигдах, үргэж дайчих	-				-			-			-
Бичил уур амьсгалын өөрчлөлт		-		-			-			-	
Байгалийн нөөц ашглалт											
Газрын нөөц баялаг	-					-		-			-
Гүний усны нөөц	-					-	-		-		
Бэлчээрийн нөөц	-					-	-				-
Эрдэс түүхий эдийн нөөц	-					-		-			-
Байгаль орчны чанарын өөрчлөлт											
Шатах тослох материал, химийн бодисоор газар доор ус бохирдох		-		-			-			-	
Тоосжилт, автомашины яндангаас гарах утаа, үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт зэргээс агаар орчин бохирдох	-			-			-		-		
ШТМ-ын хэрэглээ, хог хаягдал хадгалалт, зайлуулалттай хобоотойгоор хөрс бохирдох	-				-		-				-
Уурхайн олборлолтын улмаас үүдэлтэй тоосжилтоос ургамлан бүрхэвч бохирдох	-				-			-			-
Байгалийн өнгө, төрх, түүх соёлын дурсгалт зүйл											
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	-			-				-			-
Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	-			-				-			-
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	0			0			0		0		
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	0			0			0		0		
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	0			0			0		0		
Эдийн засаг, нийгмийн асуудал											
Улсад төлөх татвар, орлого нэмэгдэх	+				+			+		+	
Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+			+		+	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+				+			+		+	
Ажлын байр нэмэгдэх	+				+			+		+	
Төслийн хэрэгцээг дагаад орон нутгийн үйлчилгээний байгууллагын эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+				+			+		+	
Хүний эрүүл мэндэд нөлөөлөх	-	-			-		-			-	
Нийт	20	3	0	5	9	8	7	15	2	8	12

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, дэмжих зарчим баримтлан ажиллах үүрэгтэй. Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн барилгын болон үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш жил бүр энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг 2026 оны үйл ажиллагааны хүрээнд тохируулан тусгаж өгсөн болно.

2026 онд авч хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

Төв аймгийн Заамар сумын нутагт хэрэгжиж буй “Баянголын голдирол алтны шороон ордыг драгаар ашиглах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 2026 онд хийгдэх ажлын нийт зардал нь **45800 мян.төг** болж байна.

Хүснэгт 2. БОМТ-ний нийт зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		Нийт зардал (мян.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1830
		Удирдлага зохион байгуулалт	ҮА зардал
		Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	32900
		Хаалтын нөхөн сэргээлтийн зардлын хуримтлал (2026 он)	7930
		Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнд мод тарих ажлын зардал	ҮА зардал
		Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	-
		Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	0.0
		Түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	200
		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1000.0
		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1000

2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	940.0
Нийт зардал			45800

4.1 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан. Хуулийн дээрх шаардлагын дагуу алт олборлох төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1 ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 3. Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг /	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал
1	АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
	Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: Экскаватор, бульдозер, уурхайн дотоод хэрэгцээний автомашин.	Хөрс чулуулгийн овоолго, тээвэрлэлтийн зам зэрэг хөдөлгөөн ихтэй газруудад салхи ихтэй үед агаарт болон зам дагуу ус шүрших замаар тоосролтыг бууруулах арга хэмжээ авах.	Уурхайн ойр орчим	750	Уурхайн үйл ажиллагааны үед, нөхөн сэргээлтийн үе шатуудад	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 /ЗГ-ын 2013 оны 327
		Тээвэрлэлтэнд ашиглагдах автомашины бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих, машины бүхээгт	Үйл ажиллагааны турш	ҮА зардал		

		тоос нэвтрүүлэхгүй байх үүднээс жийргэвчийг цаг тухайн бүрт нь сольж байх.				дугаар тогтоолын хавсралт- Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ/ /БО-ны сайдын 1995 оны 153 дугаар тушаалын хавсралт 4- “Зүлэг, талбай усалгааны түр норм
		Тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид) болон Олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж, түүнд нийцүүлж ажиллах.	Үйл ажиллагааны турш	ҮА зардал		Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
		Гоожсон шатахуун түлшийг цэвэрлэх материалын нөөцтэй байх	Үйл ажиллагааны турш	30		
		Тоосжилт хэмжигч төхөөрөмж ашиглах	Үйл ажиллагааны турш	ҮА зардал		
	Нийт дүн			780		
	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг /	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал
2.ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ						

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						
Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоо с бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх. Шатах тослох материал, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Шимт хөрс үүсгэх	Уурхайн хөрсний овоолго	840	Барьж байгуулах болон үйл ажиллагааны үе шатуудад	MNS 5914:2008- Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт. MNS 5915:2008- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5916:2008- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, хадгалах техникийн шаардлага MNS 5917:2008- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага MNS 5918:2023- Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага. MNS 4915:2000- Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн	
	Уурхайн орчны замыг стандартын дагуу засч тэгшлэх, шаардлагатай тохиолдолд нэмж тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлэх	Үйл ажиллагааны турш	210			
	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтанд хяналт тавих, түгээгүүрийн хэсгийг хатуу хучилттай болгох	Үйл ажиллагааны турш	-			
	Машин механизмын засвар үйлчилгээ хийх талбай, ШТМ-ын агуулах, хаягдал тос хадгалах цэг, ШТС зэргийн талбайг бетон хучилттай болгох	Үйл ажиллагааны турш	ҮА зардал			
	Хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хураах	Үйл ажиллагааны турш	-			
	Ажлын талбай ба туслах зам дагуу үүссэн хотос хонхор зэрэг хөрсний элэгдэл, эвдрэлийг их бага гэхгүйгээр тухай бүр нь дүүргэх, тэгшлэх арга хэмжээ авах, талбайн эмх цэгцтэй байдлыг хангаж ажиллах	Үйл ажиллагааны турш	ҮА зардал			
	Автомашин тос масло асгарч	Үйл ажиллагаан	ШТМ хөрсөнд			

		бохирдсон хөрсийг хуулан авч тусгаарлагч гадаргуу дээр овоолон 18-20%-ийн хлораминий уусмалаар бороожуулан ариутгаж, нефтийн бүтээгдэхүүний агуулга 0.07мг/кг-аас ихгүй, 4 этилт хар тугалганы хэмжээ 0.05 мг/кг-аас ихгүй нөхцөлд буцаан байршуулах	ы турш	асгарсан тохиолд олд авч хэрэгжүүлэх ажил		сэргээлт. Техникийн шаардлага. MNS 4920:2000-Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
		Ахуйн гаралтай шингэн хаягдлыг шууд хөрсөнд шингэх байдлаар төлөвлөхгүй байх	Үйл ажиллагааны турш	-		
	Нийт дүн			1050		
	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг /	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал
3	УСНЫ НӨӨЦ, ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
		Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх (зам талбайн усалгаанаас бусад ус зарцуулалт)	Үйл ажиллагааны турш	ус ашиглуулах дүгнэлт болон гэрээгээр		
		Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах	Үйл ажиллагааны турш	-	-	
		Бохир усны хоолойг сайн чанарын хоолойг сонгож ашиглах, хяналт тавих	Үйл ажиллагааны турш	-	-	
		Болзошгүй эрсдлийн үед булингийг урсгах	Үйл ажиллагааны турш	ҮА зардал		

		хамгаалалтын далан суваг шуудууг мэргэжлийн түвшинд байгуулах				
		Тунаах нуурны бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, хүнд металлын бохирдол MNS 4943:2015 стандартаар шинжлүүлэх	Үйл ажиллагааны турш	Хяналт шинжилгээний хөтөлбөрт хамрагдана	Жилд 2 удаа	
		Усан сан бүхий эргээс 200 м-ийн дотогш олборлолт явуулахгүй байх, зурвас татах	Үйл ажиллагааны турш	-	2026 онд	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
		Усан сан бүхий эргээс 200 м-ийн дотогш автомашины тос масло асгарахаас хамгаалах, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах	Үйл ажиллагааны турш	-	2026 онд	
		Усан сан бүхий газар хог хаягдал хаягдахаас хамгаалах, ажилчдад анхааруулах, салхиар хийсч ирсэн хогийн цэвэрлэх	Үйл ажиллагааны турш	-	Жил бүр	
	Нийт дүн					
	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг /	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал
4	УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
	Уурхайн нөлөөллөөс болж ургамлан бүрхэвч доройтох, хомсдох, устаж үгүй болох	Уурхайн зөвшөөрлийн талбай болон түүний ойр орчмын талбайн ашиглалтыг сайжруулах бэлчээр эдэлбэрийг	Үйл ажиллагааны турш	Биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын зардалд орсон.		Ургамал хамгааллын тухай хууль

	цаашид бэлчээрийн доройтолд орох	хэвийн хадгалахад сум багийн удирдлагуудтай хамтран ажиллах.				
		Хөрсний нөхөн сэргээлт хийж дууссан талбайн хэсгүүдийг ургамалжуулахад зориулж үр суулгацыг туршиж бэлтгэсэн байх	Үйл ажиллагаа ны турш	Нөхөн сэргээлт ийн зардалд тусгагдс ан	Жил бүр	
		Хөрсний шинж чанар, хөрсний усны түвшинг харгалзан үзэж суулгац, олон наст ургамлын үр цацах замаар ургамалжуулна. Энд үр цацсан нөхцөлд хийсэхээс хамгаалах арга хэмжээг авсан байх	Үйл ажиллагаа ны турш	-	Жил бүр	
		Төслийн талбай болон талбайн орчмын ургамал хамгаалал, нөхөн сэргээлтэнд сөөг, сөөглөг ургамлыг ашиглах.	Үйл ажиллагаа ны турш	Нөхөн сэргээлт ийн зардал	-	
Дүн						
	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн н өртөг /мян.төг /	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал
5 АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						
	Хөрсөнд үүрлэдэг жигжиг хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд биетүүдийн амьдрах орчин алдагдах, сүйтгэгдэх	Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд газар ухаж, амьтдын үүр нүх сүйтгэхгүй байх	Үйл ажиллагаа ны турш	-	-	Амьтны тухай хууль
		Тоосжилтыг дарах усалгааг зохих хуваарийн дагуу тогтмол гүйцэтгэх	Үйл ажиллагаа ны турш	-	-	

Уурхайгаас үүдэлтэй тоосжилтоо с болж уурхайн ойр орчмын амьдрах орчин доройтох					
Хог хаягдлыг (хоолны) эмх замбараагүй хаяснаас болж зарим махчин амьтад идэх, амьтдын амьдрах орчин доройтох, бохирдох	Ахуйн хог хаягдлыг амьтад орж идэхээргүй саванд хадгалах, цаг тухай бүрт нь зайлуулах	Үйл ажиллагаа ны турш	-		
	Уурхайн кемп, засварын хэсэг, шаардлагатай газрыг ан амьтан орохоос хамгаалж хашаалах	Үйл ажиллагаа ны турш			
Дүн					
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
Энэхүү тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх		Үйл ажиллагааны турш	-		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, Галын аюулгүй ажиллагааны дүрэм ISO 14001:2004 Байгаль Орчны Удирдлагын Тогтолцоо
Уурхай болон үйлдвэрт байгаль орчны асуудал хариуцсан мэргэжлийн 1 хүний орон тоог шинээр бий болгон ажиллах		2026 он	-		
Уурхайн ажилтдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах		Үйл ажиллагааны турш	Жил бүр		
Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох дүүргийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах		Үйл ажиллагааны турш	Жил бүр		
Ажиллагсдыг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах.		110 хүн* 1100.0 =121000.0 ҮА зардал	Жил бүр		
Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах		Галын хор -150.0*35= 5250.0 ҮА зардал	Жил бүр		
Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10 ¹ дүгээр зүйлд		Гэрээгээр зохицуулагдана.	2 жилд нэг удаа		

заасны дагуу байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдтэй харилцан тохиролцох			
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 2 жил тутамд хийлгэх			
Малчдын өвөлжилтөнд дэмжлэг болох зорилгоор өвс тэжээл тараах	Саналаар	Жил бүр	
Орон нутгийн иргэдийн өрхийн орлогыг дэмжих зорилгоор урт хугацаанд хэрэгжих боломжтой төсөл хөтөлбөрийг дэмжих, санхүүжүүлэх	Саналаар	Жил бүр	
Дүн	0.0		
НИЙТ ДҮН	1830		

5.2 нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн зардал

Ашиглалтын жил	Техникийн нөхөн сэргээлтийн ажил		Биологийн нөхөн сэргээлт		Зардал, мян.төг
	Талбайн хэмжээ, га	Ажлын хэмжээ, мян.м³	Талбайн хэмжээ, га	Нэгж зардал, мян.төг	
2-р жил	6.9	103.5	6.9	6405.7	32900
Нийт	6.9	103.5	6.9	-	32900

5.3 Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө

Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд өөрийн тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд мод тарих ажлыг төлөвлөж тооцоог гаргалаа.

Хүснэгт 5. 2025 онд тарих модны хэмжээ, зардал

№	Тариалах газрын байршил		Модны нэр	Тоо ширхэг	Зардал мян.төг
1	Төв аймгийн Заамар сум Өөрийн тусгай зөвшөөрлийн талбай	2026 он	Бургас	1500	675.0
			Улиас	5000	2150
			Хайлаас	1500	1650
				8000	4475YA зардал

5.4 Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11-д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан

байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг дараах хүснэгтэнд тодорхойлсон болно.

Хүснэгт 6. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах боломжит газар	Хамгааллын арга хэмжээ	2026 он /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа
Төв аймгийн Заамар сумын нутаг	Орон нутгийн захиргааны байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх шаардлагатай газрын судалгаа гаргуулах.	Орон нутгийн саналаар	2026 оны 2-р улиралд
	Нөлөөллийн бүсэд байгаа эвдэрч, эзэнгүй орхигдсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг үе шаттай хийх.	-	2026 оны 2,3-р улиралд
	Зэрлэг ан амьтдад биотехникийн арга хэмжээ авах.		2026 онд
	Булаг, шанд, гол горхи, уст цэгийг хамгаалах, сэргээх ажилд оролцох	Орон нутгийн саналаар / зардал тодорхойгүй/	2026 оны 2,3-р улиралд
Нийт			

5.5 Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2025-2029 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

5.6 Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

Төсөл хэрэгжих MV-000290 тоот талбайд археологи, палентлогийн хайгуулын судалгаа хийгдсэн.

Хүснэгт 7. Төслийн явцад хэрэгжүүлэх түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Төв аймаг	Түүх, соёлын өв дурсгалуудын	Шаардлагатай тохиолдолд		Төслийн эхний	Соёлын өвийг

Заамар сум	талаарх мэдээлэлд анхааралтай хандах, сэргээх ажилд оролцох			шатанд	хамгаалах тухай хууль
	Шаардлагатай тохиолдолд судалгааг дахин хийх тохиолдолд идэвхитэй оролцох	Санхүүжүүлэх	ҮАЗардалд	Тухай үед	-
	Нутгийн иргэдийн уламжлалт амьдралын хэв маяг, тахилга шүтлэгт хүндэтгэлтэй хандах, дэмжлэг үзүүлэх	Хандив өгөх	200.0	Тухай үед	-
НИЙТ ДҮН			200		

5.7 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 8. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Нийт төсөл хэрэгжих талбай, барилга байгууламжинд	-	Өдөр бүр, тогтмол /уурхайн байгаль орчны мэргэжилтэн хариуцна/	Гамшигаас хамгаалах тухай хууль
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэргэжлийн хүнээр сургалт хийлгэх	Уурхайн бүх ажилчдад	300.0	Сургалтыг 2 ээлжийн ажилчдад 1 удаа,	
	Гал гарсан тохиолдолд хэрэглэх	Уурхайн хэмжээнд ашиглагдах бүх	-		

	галын иж бүрдлийг бэлэн байлгах, бүрэн бүтэн байдлыг хангах, хугацааг шалгаж байх, дууссан тохиолдолд сунгуулах	галын иж бүрдэл			
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	-		
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Үйл ажиллагааны турш	200.0		
	Уурхайн нийт ажилчдад ХАБЭА сургалт зохион байгуулж, уурхайн эрсдлийн менежментийн дагуу ажиллахыг зааварлах, дадлагажуулах	Жил бүр	-		MNS 4968:2000 MNS 6437:2014
	Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй орон нутгийн иргэд, мал амьтан, уурхайн ажилчид болзошгүй аюулд өртөх эрсдэлд зарцуулах	Жил бүр эсвэл улиралд	500.0		

	хуримтлал үүсгэх				
	Нийт		1000.0		

5.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн Өртөг /мян.төг/	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээ с орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ангиалан ялгаж, зайлуулах, дахин ашиглах тогтолцоог нэвтрүүлэх	Үйл ажиллагаан ы турш	150.0	Жил бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд БОАЖС, Сангийн сайд А- 429/257 тушаалын хавсралт БОАЖС А/428 тушаал Хоог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэ х журам
	Хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгаж байх	Үйл ажиллагаан ы турш	70.0		
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, аль болох олон газарт байрлуулах	2026 онд засаж сайжруулах, нэмж байршуулах	350		
	Хаягдал тос масло цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хийсэн гэрээний дагуу хаягдал тос маслыг нийлүүлэх	Үйл ажиллагаан ы турш	Хэрэглээний хэмжээгээр	Жил бүр	Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Тос маслоны хуванцар савыг нийлүүлэгчид эргүүлэн өгөх, дахин ШТМ хийлгэн авах	Үйл ажиллагаан ы турш	-	Ашиглалтаар	
	Хаягдал тосыг хуримтлуулах сав байрлуулах	Үйл ажиллагаан ы турш	-		
	Хаягдал дугуй	Үйл	-		

	болон төмрийн хаягдлыг ангиан цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	ажиллагаан ы турш			
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангиан цуглуулах цэгийг хашаажуулах, тэмдэг тэмдэглэгээ тавих	Үйл ажиллагаан ы турш	220		
	Хог хаягдлын хор уршиг, ангиан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах	Үйл ажиллагаан ы турш	-	Жил бүр	
	А-429/257-р тушаалын хавсралтад заасан хаягдлыг дахин ашиглах боломжтой нийлүүлэгчид эргүүлэн өгөх, аль болох дахин ашиглах боломжтой нийлүүлэгчийг сонгон авах.	-			
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ялган ангилж бүртгэлжүүлэх	Үйл ажиллагаан ы турш	-	Жил бүр	
	Энгийн болон аюулгүй хог хаягдлыг ялган ангилж коджуулах	Үйл ажиллагаан ы турш	-	Жил бүр	
	Коджуулж ангилсан хаягдлыг харьяа сумын	Үйл ажиллагаан ы турш	-	Жил бүрийн 12-р сарын 20-ны дотор	

	БО газарт бүртгүүлэх				
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлыг тусгай бодис хэрэглэн задлах	2026 он	210	Төслийн эхэн үед болон ашиглалтын үед	
Нийт			1000		

5.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 3.1 дүгээр зүйл, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуульд зааснаар төслийг хэрэгжүүлэх явцад төслөөс байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) гэнэ.

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр нь “Баянголын голдирол алтны үүсмэл болон шороон ордыг драгаар ашиглах” төсөл хэрэгжиж буй бүс нутагт гарч болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг тайлагнах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлтийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх мөн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ нь байгаль орчны стандарт, норм нормативаар тогтоосон хэмжээнээс хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Уг хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжих газрын агаар, усны чанар, хөрс, амьтан, ургамлын асуудлыг онцлон анхааран авч үзсэн бөгөөд байгаль орчны бохирдол, өөрчлөлтийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол улсын хууль тогтоомж, стандарт, дүрэм, заавар арга зүйг баримтлах шаардлагатай.

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт үүд	Байршил	Хугацаа ба давтамж	БО-ны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт, аргачлал	Дээд доод хязгаар
Агаарын чанар, бохирдлын мониторинг							
Тоос: PM2.5, PM10, Нийт тоос Утааны хий: Хүхэрлэг хий, Азотын давхар исэл, Угаарын хий	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд	Жилд 2 удаа	Уурхайлалт явагдаж буй талбайд	220.0	400.0	MNS 0017-2-5-12:1988 MNS ISO 4221: 2002 MNS0012-1-003:1982 MNS 0017-2-5-11:1988 MNS 4048:1988 ISO 16017-1:2000 ISO 16362-2:2003 MNS 5365:2004	24 цагийн дундаж: Нийт тоос-150 мкг/м ³
	Драгын талбай, хөрсний овоолго 2 цэг		Уурхай болон үйлдвэрийн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах	100.0		PM2.5-50 мкг/м ³ PM10-100 мкг/м ³ SO ₂ -20 мкг/м ³	
	Хүнд даацын машины тээврийн зам, баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим		Машин механизм ажиллагаа, хөдөлгөөн өөр шуугиан үүсэх	80.0		MNS-5919:2008 MNS ISO 4226:2000 MNS ISO 4227:2002 MNS 4585:2007 MNS 5885:2008	NO ₂ -40 мкг/м ³ CO-3000 мкг/м ³ 0 мкг/м ³
Дүн /мян.төг/					400.0		
Усны нөөц, чанар, бохирдлын мониторинг							
Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар),	Ундны ус авч хэрэглэж буй уст цэг	Үйл ажиллагааны үед жилд 2 удаа	Төслийн талбай орчим	150.0	300.0	MNS6148: 2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуул агч бодисын	Газрын доорхи ус: рН-6.5 – 8.5
	Технологийн усны хэрэглээн			150.0			

усны ерөнхий болон хүнд металлы н шинжилг ээ	ий эх үүсвэр буюу гадаргын ус					зөвшөөрөг дөх дээд хэмжээ	NH ₄ - 3.0 мгN/ л NO ₂ – 1 мг/л NO ₃ - 50 мг/л PO ₄ – 3.5 мг/л Cl – 350 мг/л F – 1.5 мг/л SO ₄ - 500 мг/л Mn- 0.1 мг/л Ag- 0.1 мг/л Fe- 0.3 мг/л
Дүн /мян.төг/						300.0	
Хөрсний чанар, бохирдлын мониторинг							
Хөрсний морфоло ги бичиглэл , рН, цахилгаа н дамжуул алт, давс%, ялзмагий н агуулам ж%, шим тэжээлий н элемент,	Төслийн талбайд 4 цэг сонгох ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолт од өртөөгүй цэгт Угаан баяжуулах үйлдвэрий н хашаанд Тунгаах	Жилд 2 удаа	Хөрсний элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдө х	120.0	240.0	MNS 2305- 94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; MNS 3298- 1991 Шинжилгэ эний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагу уд;	Pb- 100 мг/кг Cd-3 мг/кг As-6 мг/кг Cu- 100 мг/кг Zn- 300 мг/кг

хөрсний механик бүрэлдэх үүн, нүүрс устөрөгч ийн нэгдлүүд	нуурын орчим					MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуул агч бодис, элементүү дийн зөвшөөрөг дөх дээд хэмжээ; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуул агч бодис, элементүү дийн зөвшөөрөг дөх дээд хэмжээ	
Хүнд металлы н агуулам ж	Дээрх 4 цэгт	Жилд 2 удаа	Түлш, тосолгоон ы материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох Угаан баяжуула х үйлдвэри йн хашаанд Тунгаах нуурын орчим	120.0			
Дүн /мян.төг/						240.0	
Нийт /мян.төг/						940.0	

**6. БОМТ-ний хэрэгжилтийн талаар
нөлөөлөлд өртөгч оршин суугчид,
оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө**

Төсөл хэрэгжүүлэгч “Баянгол эко Заамар” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын мэргэжилтэн, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь нутаг дэвсгэрийн сум, багийн нийтийн иргэдийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

Хүснэгт 11. БОМТ тайлагнах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн	Жилийн эцэст (12.01-нд)	Цаашид төлөвлөгөөнд шинээр тусгах зүйлс	Улаанбаатар хот

Төв аймгийн байгаль орчны газар	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн	Жилийн эцэст (11.01-нд)	Цаашид анхаарах зүйлс, хамтран ажиллах	Төв аймаг
Төв сумын Засаг даргын тамгийн газар	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй	Хагас жил, жилийн эцэст	Хамтран ажиллах	Заамар сум
Заамар сумын Хайлааст багийн Иргэдийн нийтийн хурал	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	холбоотой фото зургаар баталгаажсан байна.	Хагас жил, жилийн эцэст	Хамтран ажиллах	Багийн ИНХ

